

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/144/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2024 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

2025.02.18 № 56
тантай _____ -ны № _____ -т

ЦЭНГЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ДАРГА
Х.СОРОНЗОНБОЛД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Тус газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

8325P2090044

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.АЙГҮЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>67,226,001.0000</u>	<u>27,809,001.0000</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
31140	Касс арилжааны банк	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	-	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	4,780,001.0000	7,809,001.0000
354	Хангамжийн материал	4,780,001.0000	7,809,001.0000
35410	Бичиг хэргийн материал	-	-
35470	Бусад хангамжийн материал	4,780,001.0000	7,809,001.0000
36	НӨӨЦИЙН БАРАА	62,446,000.0000	20,000,000.0000
36300	Тэжээлийн нөөц	62,446,000.0000	20,000,000.0000
36400	Шатахууны нөөц	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,269,099,853.4700</u>	<u>4,971,598,017.0700</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>4,269,099,853.4700</u>	<u>4,971,598,017.0700</u>
392	Биет хөрөнгө	4,106,116,614.4700	4,808,232,671.1300
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,182,641,782.0000	2,773,115,412.0000
39202	Хуримтлагдсан элэгдэл	(786,720,875.2200)	(827,592,495.1800)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	147,865,696.0000	182,590,696.0000
39204	Хуримтлагдсан элэгдэл	(137,395,699.2400)	(117,486,426.9600)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,747,899,517.0000	3,925,847,567.0000
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,237,472,120.0900)	(2,405,338,262.0300)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,859,020.0000	41,062,620.0000
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,910,246.7500)	(18,140,308.5900)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,305,379,678.0000	1,425,379,678.0000
39210	Хуримтлагдсан элэгдэл	(301,103,274.2300)	(371,508,721.3100)
39214	Бусад үндсэн хөрөнгө	425,570,076.0000	485,570,076.0000
39215	Хуримтлагдсан элэгдэл	(254,496,939.0000)	(285,267,163.8000)
393	Биет бус хөрөнгө	<u>162,983,239.0000</u>	<u>163,365,345.9400</u>

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39301	Программ хангамж	1,973,239.0000	2,743,239.0000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.0000)	(937,893.0600)
39303	Бусад биет бус хөрөнгө	161,560,000.0000	161,560,000.0000
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,336,325,854.4700</u>	<u>4,999,407,018.0700</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,336,325,854.4700</u>	<u>4,999,407,018.0700</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,336,325,854.4700	4,999,407,018.0700
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	520,738,962.0000	520,738,962.0000
51101	Өмч: - төрийн	520,738,962.0000	520,738,962.0000
512	Хуримтлагдсан үр дүн	3,342,330,227.3800	4,005,411,390.9800
51210	Өмнөх үеийн үр дүн	3,581,213,773.4700	3,342,330,227.3800
51220	Тайлант үеийн үр дүн	(238,883,546.0900)	663,081,163.6000
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	473,256,665.0900	473,256,665.0900
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,336,325,854.4700</u>	<u>4,999,407,018.0700</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	830,172,866.00	2,269,752,267.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	116,147,139.00	1,013,791,540.00
120	Нийтлэг татварын бус орлого	116,147,139.00	1,013,791,540.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	76,147,139.00	993,791,540.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	40,000,000.00	20,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	714,025,727.00	1,255,960,727.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,235,981.00	27,251,027.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	30,000,000.00	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,235,981.00	17,251,027.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	670,789,746.00	1,228,709,700.00

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	670,789,746.00	1,228,709,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,069,056,412.09	1,606,671,103.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,069,056,412.09	1,606,671,103.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,024,360,376.75	1,484,877,846.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	420,718,903.00	802,533,073.12
210101	Үндсэн цалин	295,521,460.00	431,901,381.12
210102	Нэмэгдэл	117,058,069.00	353,151,873.00
210104	Урамшуулал	8,139,374.00	17,479,819.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,019,700.00	94,890,700.00
210201	Тэтгэврийн даатгал	38,093,400.00	61,704,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,481,600.00	8,296,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,585,300.00	4,148,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	896,300.00	4,148,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,963,100.00	16,593,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,354,648.00	42,546,225.45
210301	Гэрэл, цахилгаан	2,269,236.00	3,415,187.45
210302	Түлш, халаалт	28,085,412.00	39,131,038.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,763,384.00	42,179,727.00
210401	Бичиг хэрэг	3,386,000.00	4,191,750.00
210402	Тээвэр, шатахуун	34,605,423.00	33,327,077.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,444,961.00	4,190,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000.00	470,000.00
2105	Нормативт зардал	430,000.00	617,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000.00	617,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	943,800.00	628,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	352,300.00	179,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	60,300.00	
210604	Урсгал засвар	531,200.00	449,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,999,500.00	7,094,000.00
210702	Дотоод албан томилолт	6,999,500.00	7,094,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,779,008.66	3,276,305.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,995,710.66	2,467,925.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	223,850.00	277,980.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,000.00	61,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	498,800.00	410,000.00
210807	Газрын төлбөр	53,648.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	459,351,433.09	491,112,016.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	154,157,248.00	166,339,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	541,300.00	5,200,000.00

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	304,652,885.09	319,572,116.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,696,035.34	121,793,256.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	39,222,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	39,222,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	44,696,035.34	82,571,256.43
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,696,035.34	82,571,256.43
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж	-	-
221001	Их засвар	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(238,883,546.09)	663,081,163.60
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
145003	Хөрөнгө оруулалтын олз	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(238,883,546.09)	663,081,163.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	714,025,727.00	1,255,960,727.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	714,025,727.00	1,255,960,727.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,235,981.00	27,251,027.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	30,000,000.00	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,235,981.00	17,251,027.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	670,789,746.00	1,228,709,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	670,789,746.00	1,228,709,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	705,255,727.00	1,227,681,987.00

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21	УРСГАЛ ЗАРДАЛ	705,255,727.00	1,227,681,987.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	660,559,691.66	1,105,888,730.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	420,463,098.00	802,533,073.12
210101	Үндсэн цалин	295,265,655.00	431,901,381.12
210102	Нэмэгдэл	117,058,069.00	353,151,873.00
210104	Урамшуулал	8,139,374.00	17,479,819.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,019,700.00	94,890,700.00
210201	Тэтгэврийн даатгал	38,093,400.00	61,704,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,481,600.00	8,296,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,585,300.00	4,148,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	896,300.00	4,148,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,963,100.00	16,593,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,354,648.00	42,546,225.45
210301	Гэрэл, цахилгаан	2,269,236.00	3,415,187.45
210302	Түлш, халаалт	28,085,412.00	39,131,038.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,763,384.00	44,566,327.00
210401	Бичиг хэрэг	3,386,000.00	4,191,750.00
210402	Тээвэр, шатахуун	34,605,423.00	35,713,677.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,444,961.00	4,190,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,000.00	470,000.00
2105	Нормативт зардал	430,000.00	617,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	430,000.00	617,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,043,800.00	857,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	352,300.00	408,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	60,300.00	
210604	Урсгал засвар	631,200.00	449,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,999,500.00	7,094,000.00
210702	Дотоод албан томилолт	6,999,500.00	7,094,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,480,813.66	6,726,305.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,697,515.66	5,917,925.00
210803	Даатгалын үйлчилгээ		59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	223,850.00	277,980.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,000.00	61,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	498,800.00	410,000.00
210807	Газрын төлбөр	53,648.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,004,748.00	106,057,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,463,448.00	100,857,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	541,300.00	5,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,696,035.34	121,793,256.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	39,222,000.00

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		39,222,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	44,696,035.34	82,571,256.43
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,696,035.34	82,571,256.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>8,770,000.00</u>	<u>28,278,740.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,770,000.00	28,278,740.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,770,000.00	28,278,740.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,770,000.00	28,278,740.00
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,770,000.00	28,278,740.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(8,770,000.00)</u>	<u>(28,278,740.00)</u>
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
250003	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	520,738,962.00	473,256,665.09	3,581,213,773.47	4,575,209,400.56
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	520,738,962.00	473,256,665.09	3,581,213,773.47	4,575,209,400.56
C07	Тайлант үеийн үр дүн				
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,738,962.00	473,256,665.09	3,581,213,773.47	4,575,209,400.56
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	520,738,962.00	473,256,665.09	3,581,213,773.47	4,575,209,400.56
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	520,738,962.00	473,256,665.09	3,342,330,227.38	4,336,325,854.47
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
D08	Тайлант үеийн үр дүн			663,081,163.60	663,081,163.60
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,738,962.00	473,256,665.09	4,005,411,390.98	4,999,407,018.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,361,391,800.00	1,153,208,443.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,361,391,800.00	1,153,208,443.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,320,518,800.00	1,113,986,443.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	829,647,900.00	802,533,073.12
210101	Үндсэн цалин	458,581,000.00	431,901,381.12
210102	Нэмэгдэл	351,067,900.00	353,151,873.00
210104	Урамшуулал	19,999,000.00	17,479,819.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,973,500.00	94,890,700.00
210201	Тэтгэврийн даатгал	73,787,600.00	61,704,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,296,500.00	8,296,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,148,200.00	4,148,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,148,200.00	4,148,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,593,000.00	16,593,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,382,200.00	42,546,225.45
210301	Гэрэл, цахилгаан	3,500,000.00	3,415,187.45
210302	Түлш, халаалт	53,882,200.00	39,131,038.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	46,873,100.00	42,180,650.00

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	6,162,000.00	4,191,750.00
210402	Тээвэр, шатахуун	34,187,600.00	33,328,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,353,500.00	4,190,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	470,000.00	470,000.00
2105	Нормативт зардал	700,000.00	617,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,000.00	617,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,886,600.00	7,623,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,243,400.00	3,108,000.00
210602	Тавилга	19,000,000.00	4,065,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	143,200.00	
210604	Урсгал засвар	31,500,000.00	449,500.00
2107	Томилолт, зочны зардал	7,100,000.00	7,094,000.00
210702	Дотоод албан томилолт	7,100,000.00	7,094,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,483,500.00	8,726,305.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,119,500.00	7,917,925.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	513,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	184,800.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	392,000.00	277,980.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,400.00	61,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	981,000.00	410,000.00
210807	Газрын төлбөр	128,500.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	44,300.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	173,472,000.00	107,775,090.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	167,550,000.00	102,575,090.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,922,000.00	5,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,873,000.00	39,222,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,873,000.00	39,222,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	39,822,000.00	39,222,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,051,000.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,361,391,800.00	1,153,208,443.57
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,361,391,800.00	1,153,208,443.57
132001	Орон нутгийн төсвөөс	1,361,391,800.00	1,153,208,443.57
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	27	27
620001	Удирдах ажилтан	12	12

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

620002	Гүйцэтгэх ажилтан	10	10
620003	Үйлчлэх ажилтан	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27	27
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	11	11

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,060,893.00	27,251,027.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,060,893.00	27,251,027.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,060,893.00	20,181,027.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,717,923.00	2,385,677.00
210402	Тээвэр, шатахуун	2,707,923.00	2,385,677.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,000.00	
2107	Томилолт, зочны зардал	1,130,000.00	-
210702	Дотоод албан томилолт	1,130,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,212,970.00	17,795,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,212,970.00	17,795,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	175,088.00	7,070,000.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	175,088.00	7,070,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	43,235,981.00	27,251,027.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,235,981.00	27,251,027.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	30,000,000.00	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,235,981.00	17,251,027.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд “Хүний нөөц, газар, байгалийн баялаг, мал аж ахуй, дэд бүтцийн давуу талдаа тулгуурласан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, үйлдвэр, аялал жуулчлал, нийгмийн үйлчилгээний харилцан бие биеэ нөхөх зөв зохистой бүтэц бүхий цогц салбаруудыг хөгжүүлж хүн амын амьдрах таатай орчныг бүрдүүлсэн сум болно.” зорилго дэвшүүлжээ.

Дээрх зорилгын хүрээнд доорх дэд зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- I. Уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн даацад нийцсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлнэ.
- II. Хадлан бэлчээрийн нөөцийг сайжруулж, бэлчээр ашиглалтын хамтын менежментийг төлөвшүүлнэ.
- III. Сумын хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тус албанаас Цэнгэл сумын Засаг даргын тамгын газарт хяналт шалгалт хийгдээгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 663.1 сая төгрөгөөр буюу 5.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		-	-
Авлага	-		-
Урьдчилж гарсан зардал			-
Бараа материал	4,780.00	7,809.00	3,029.00
Нөөцийн бараа	62,446.00	20,000.00	(42,446.00)
Үндсэн хөрөнгө	4,269,099.85	4,971,598.02	702,498.16
<u>Нийт хөрөнгө</u>	<u>4,336,325.85</u>	<u>4,999,407.02</u>	<u>663,081.16</u>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,336,325.85	4,999,407.02	663,081.16
<u>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</u>	<u>4,336,325.85</u>	<u>4,999,407.02</u>	<u>663,081.16</u>

Эх сурвалж: Аудитын судалгаа

Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, өр төлбөр дансдад өөрчлөлт ороогүй, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансдад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын данс 39.4 сая төгрөгөөр буурсан нь сумын ОНХС-гийн хөрөнгөөр бэлтгэсэн нөөцийн өвс тэжээлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 702.5 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 28.3 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 993.8 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөнд 319.6 сая төгрөгийн элэгдэл байгуулж, элэгдлээ нөхсөн 24.9 сая төгрөгийн авто тээврийн хэрэгслийг ОНӨГ-ын тогтоолоор сумын ИТХ-ын балансад шилжүүлж нийт дүнгээр өссөн байна.

Тайлант онд 663.1 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 633.1 сая төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Орон нутгийн төсвөөс 1,153.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж орон нутгийн төсвөөс санхүүжих төсвийг 1,361.4 төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслөөс илүү байгаа нь 2024 онд цалин хөлс, орон нутгийн нэмэгдэл цалин нэмэгдсэнтэй холбоотой зардлыг тодотгож өгсөнтэй холбоотой илүү байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1361.4 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,153.2 сая төгрөгийн санхүүжилтийг авч, батлагдсан төсвөөс 75.5 сая төгрөгийг орон нутагт төвлөрүүлж, 132.7 сая төгрөгийн дутуу санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,153.2 сая төгрөг буюу 84.7 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-70106					
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	927,219.30	765,836.40	161,382.90	82.6
2	80102-Туслах үйл ажиллагааны зардал	310,123.50	303,262.54	6,860.96	97.8
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	40,873.00	39,222.00	1,651.00	96.0
4	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	50,000.00	37,187.50	12,812.50	74.4

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	33,176.00	7,700.00	25,476.00	23.2
	Дүн	1,361,391.80	1,153,208.44	208,183.36	84.7

Эх сурвалж: Аудитын судалгаа

Үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрөөс 161.4 сая төгрөгийг, туслах үйл ажиллагааны хөтөлбөрөөс 6.9 сая төгрөгийг, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлаас 1.7 сая төгрөг, орон нутгийн нөөц хөрөнгө хөтөлбөрөөс 15.6 сая төгрөг, байгаль хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрөөс 12.8 сая төгрөгийн нийтдээ 208.1 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй байгаа нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүй байгаатай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь ахмадын сан байгуулаагүй, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 37.4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 89.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвөөс 2024 онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн /210801/ төсвөөс 7.8 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардлын /210901/ төсвөөс 102.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Тус байгууллагад 2024 онд 27 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр удирдах ажилтан 12, гүйцэтгэх ажилтан 10, үйлчлэх ажилтан 5, нийтдээ 27 орон тоогоор батлагдсан орон тоо, төсөвт багтаан ажилласан байна

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар нь нь дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 10.0 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 17.3 сая төгрөгийн нийтдээ 27.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, хангамж, бараа материалын зардалд 2.4 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 17.8 сая төгрөгийг хамруулан зарцуулж, оны эцэст 7.1 сая төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Засаг даргын тамгын газар нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Батлагдсан төсвийн хүрээнд 66.9 сая төгрөгийн бараа материал, 28.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 03/20 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,069.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 16.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг барагдуулж ажилласан, алдаа зөрчил гараагүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц онц асуудал байхгүй боловч санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайлагнал, санхүүгийн баримтыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул хөтөлбөр арга хэмжээний зардлууд болон төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтыг үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой залруулга гараагүй. Аудитаар 3.9 сая төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 3.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

1.Сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Б/06 дугаар захирамжаар 1 албан хаагчид, сумын Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Б/05 дугаар тушаалаар 4 албан хаагчид 2024 оны 4 дүгээр сард хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллын тооцоогоор 5 албан хаагчид нийт 39.2 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгохдоо 3.9 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Татварын хууль тогтоомжид хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно”, 6.1.19-д “суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг”, 28 дугаар зүйлийн 28.7-д “Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.”,Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 21-р зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,..... тооцон албан татвар ногдуулна”, 25 дугаар зүйлийн 25.1-д “Энэ хуулийн 4.1.11-д заасан суутгаан төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална”, 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр барагдуулах акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/			
									Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллаас хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй олгосон.	1	3,922.2	1	3,922.2								
Дүн	1	3,922.2	1	3,922.2								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Цэнгэл сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								